

“ХААН СОЁМБО АУДИТ- ХХК



САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/132/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Л.Мөнх-Оргил
Утас: 99039344 Цахим хаяг: munkhorgill@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Гүйцэтгэсэн аудитор: Н.Ган-эрдэнэ
Утас: 88115349 Цахим хаяг: ganerdene1083@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/218
танай _____ -ны № _____ -т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд 4,270.0 мянган төгрөгийн бараа материал, 41,100.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн ажилтанд олгосон урамшуулал, төсвийн хөрөнгийн зарцуулалт, нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 15,928.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, зөрчлийг дахин давтахгүй байх 3 зөвлөмжийг хүргүүлж ажилласан.

Бусад асуудлын хэсэг

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын хүүхдийн цэцэрлэг эрхлэгч нь Боловсрол шинжлэх ухааны газрын даргатай 7 чиглэлээр 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө баталж, үр дүнгийг гэрээ байгуулсан байна. 2024.12.27 ны өдөр Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн ажил үнэлж, дүгнэх ажлын хэсэгт ажлаа дүгнүүлэн 2025 оны 01 дүгээр сарын 15-ний өдрийн 1/20 тоот тушаалаар үнэлгээг баталгаажуулсан байна. Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын хүүхдийн цэцэрлэг нь 2024 онд ажлын үр дүнгийн үнэлгээгээр 96%-иар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	158,447,485.65	235,848,238.55
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	95,576,563.86	173,785,991.59
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	95,576,563.86	173,785,991.59
3121	Төгрөг	95,576,563.86	173,785,991.59
31221	Төрийн сангийн харилцах	95,576,563.86	173,785,991.59
33	АВЛАГА	7,722,084.50	7,311,096.24
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0	1,349,466.74
335	Бусад авлага	7,722,084.50	5,961,629.50
3351	Байгууллагаас авах авлага	500	0
3352	Хувь хүмүүсээс авах авлага	7,721,584.50	5,961,629.50
35	БАРАА МАТЕРИАЛ	55,148,837.29	54,751,150.72
351	Түүхий эд материал	9,770,993.52	9,770,993.52
35110	Тусгай зориулалттай материал	8,724,143.52	8,724,143.52
35130	Эм боох материал	1,046,850.00	1,046,850.00
354	Хангамжийн материал	45,122,843.77	44,980,157.20
35410	Бичиг хэргийн материал	416,902.00	3,626,002.00
35420	Аж ахуйн материал	19,902,516.15	24,731,316.15
35440	Түлш, шатах тослох материал	1,000,000.00	1,000,000.00
35450	Барилгын засварын материал	4,439,000.00	4,331,000.00
35460	Хүнсний материал	19,364,425.62	7,021,839.05
35470	Бусад хангамжийн материал	0	4,270,000.00
35600	Мал амьтад	255,000.00	0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	162,180,452.02	171,421,659.27
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	162,180,452.02	171,421,659.27
391	Газар	0	0
392	Биет хөрөнгө	152,900,452.02	162,141,659.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	165,374,093.03	165,120,505.03
39202	Хуримтлагдсан элэгдэл	-58,895,692.27	-71,768,636.96
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	72,881,885.08	90,330,573.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-39,691,906.41	-50,068,437.08
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,729,086.49	56,935,367.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	-32,131,059.90	-31,041,758.12
39217	Ном	2,634,046.00	2,634,046.00
393	Биет бус хөрөнгө	9,280,000.00	9,280,000.00
39301	Програм хангамж	275,000.00	275,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-275,000.00	-275,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	9,280,000.00	9,280,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	0	0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	320,627,937.67	407,269,897.82
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	452,000.00	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	452,000.00	0
413	Өглөг	452,000.00	0
4136	Бусад өглөг	452,000.00	0
41361	Байгууллагад төлөх өглөг	452,000.00	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	320,175,937.67	407,269,897.82
51	Засгийн газрын хувь оролцоо	320,175,937.67	407,269,897.82
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	152,762,004.78	152,762,004.78
51101	Өмч: - төрийн	152,762,004.78	152,762,004.78
512	Хуримтлагдсан үр дүн	100,282,357.61	187,629,905.76
51210	Өмнөх үеийн үр дүн	100,282,357.61	100,535,945.61
51220	Тайлант үеийн үр дүн	0	87,093,960.15
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	67,131,575.28	66,877,987.28
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	320,627,937.67	407,269,897.82

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	529,021,623.00	789,328,395.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,902,123.00	47,165,695.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,902,123.00	47,165,695.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,902,123.00	47,165,695.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.00	1,759,955.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	11,832,123.00	45,370,740.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	517,119,500.00	742,162,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	480,967,000.00	694,010,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	480,967,000.00	694,010,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	36,152,500.00	48,152,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	36,152,500.00	48,152,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	481,194,282.76	701,550,054.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	481,194,282.76	701,550,054.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	474,547,668.66	687,194,315.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	308,365,704.16	496,525,366.04
210101	Үндсэн цалин	225,306,113.27	333,632,886.32
210102	Нэмэгдэл	73,433,785.79	140,690,111.91
210104	Урамшуулал	9,625,805.10	22,202,367.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,574,624.35	60,517,604.49
210201	Тэтгэврийн даатгал	26,433,057.04	42,275,886.17
210202	Тэтгэмжийн даатгал	2,922,117.56	4,681,715.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,462,087.31	2,486,816.93
210204	Ажилгүйдлийн даатгал	566,560.50	2,422,546.95
210205	Эрүүл мэндийн даатгал	6,190,801.94	8,650,639.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,505,885.90	24,796,760.50
210301	Гэрэл, цахилгаан	1,887,421.80	1,960,201.78
210302	Түлш, халаалт	18,530,464.10	22,836,558.72
210303	Цэвэр, бохир ус	88,000.00	0
2104	Хангамж, бараа материалын зардал	20,574,051.57	11,944,600.00
210401	Бичиг хэрэг	3,220,800.00	4,874,600.00
210402	Тээвэр, шатахуун	5,676,735.00	3,848,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0	584,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,335,150.00	2,382,400.00
210408	Бараа материал акталсны зардал	5,341,366.57	255,000.00
2105	Нормативт зардал	39,501,511.38	46,361,831.57
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,141,600.00	0
210502	Хоол, хүнс	37,559,911.38	46,361,831.57
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000,000.00	9,108,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	9,108,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	752,000.00	750,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	752,000.00	750,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,273,891.30	37,190,152.77
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,374,384.50	6,015,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,486,000.00	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,413,506.80	31,175,152.77
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,646,614.10	14,355,739.50
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,646,614.10	14,355,739.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	47,827,340.24	87,778,340.13
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	7,721,584.50	0

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	7,721,584.50	0
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	684,379.98
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0	684,379.98
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	7,721,584.50	-684,379.98
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	55,548,924.74	87,093,960.15

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	152,762,004.78	67,131,575.28	44,733,432.87	264,627,012.93
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	152,762,004.78	67,131,575.28	44,733,432.87	264,627,012.93
C07	Тайлант үеийн үр дүн	0	0	55,548,924.74	55,548,924.74
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	152,762,004.78	67,131,575.28	100,282,357.61	320,175,937.67
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	152,762,004.78	67,131,575.28	100,282,357.61	320,175,937.67
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	253,588.00	253,588.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	152,762,004.78	67,131,575.28	100,535,945.61	320,429,525.67
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0	-253,588.00	0	-253,588.00
D08	Тайлант үеийн үр дүн	0	0	87,093,960.15	87,093,960.15
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	152,762,004.78	66,877,987.28	187,629,905.76	407,269,897.82

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	517,189,500.00	743,957,655.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	70,000.00	1,794,955.00
120	Нийтлэг татварын бус орлого	70,000.00	1,794,955.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	70,000.00	1,794,955.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.00	1,759,955.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	517,119,500.00	742,162,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	480,967,000.00	694,010,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	480,967,000.00	694,010,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	36,152,500.00	48,152,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	36,152,500.00	48,152,500.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	0	0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	449,854,828.51	665,748,227.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	449,854,828.51	665,748,227.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	443,208,214.41	651,392,487.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	308,365,704.16	496,525,366.04
210101	Үндсэн цалин	225,306,113.27	333,632,886.32
210102	Нэмэгдэл	73,433,785.79	140,690,111.91
210104	Урамшуулал	9,625,805.10	22,202,367.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,574,624.35	61,867,071.23

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	26,253,181.74	42,275,886.17
210202	Тэтгэмжийн даатгал	3,088,609.85	4,973,633.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,462,087.31	2,504,816.93
210204	Ажилгүйдлийн даатгал	615,521.99	2,422,546.95
210205	Эрүүл мэндийн даатгал	6,155,223.46	9,690,187.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,505,885.90	24,796,760.50
210301	Гэрэл, цахилгаан	1,887,421.80	1,960,201.78
210302	Түлш, халаалт	19,530,464.10	22,836,558.72
210303	Цэвэр, бохир ус	88,000.00	0
210502	Хоол, хүнс	48,869,710.00	32,206,790.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,000,000.00	9,000,000.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	9,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	881,800.00	750,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	881,800.00	750,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,010,490.00	26,246,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,524,490.00	19,794,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,486,000.00	6,451,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,646,614.10	14,355,739.50
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,646,614.10	14,355,739.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	67,334,671.49	78,209,427.73
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0	0
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	67,334,671.49	78,209,427.73
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	28,241,892.37	95,576,563.86
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	95,576,563.86	173,785,991.59

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан: Улсын төсөв

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	95,576,563.86		-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	787,790,300.00	617,595,727.27	170,194,572.73	78.4
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	787,790,300.00	617,595,727.27	170,194,572.73	78.4
210	Бараа, үйлчилгээний зардал	787,790,300.00	617,595,727.27	170,194,572.73	78.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	626,716,100.00	496,525,366.04	130,190,733.96	79.2
210101	Үндсэн цалин	428,139,600.00	333,632,886.32	94,506,713.68	77.9
210102	Нэмэгдэл	186,636,100.00	140,690,111.91	45,945,988.09	75.4
210104	Урамшуулал	11,940,400.00	22,202,367.81	-10,261,967.81	185.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,246,200.00	61,867,071.23	9,379,128.77	86.8
210201	Тэтгэврийн даатгал	48,449,100.00	42,275,886.17	6,173,213.83	87.3
210202	Тэтгэмжийн даатгал	5,698,000.00	4,973,633.67	724,366.33	87.3
210203	ҮОМШӨ ний даатгал	2,849,800.00	2,504,816.93	344,983.07	87.9
210204	Ажилгүйдлийн даатгал	2,849,800.00	2,422,546.95	427,253.05	85.0
210205	Эрүүл мэндийн даатгал	11,399,500.00	9,690,187.51	1,709,312.49	85.0
2105	Нормативт зардал	56,296,600.00	32,206,790.00	24,089,810.00	57.2
210502	Хоол, хүнс	56,296,600.00	32,206,790.00	24,089,810.00	57.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2,122,100.00	750,000.00	1,372,100.00	35.3

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210806	Мэдээллийн технологийн зардал	2,122,100.00	750,000.00	1,372,100.00	35.3
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	31,409,300.00	26,246,500.00	5,162,800.00	83.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,957,600.00	19,794,800.00	5,162,800.00	79.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,451,700.00	6,451,700.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	787,790,300.00	695,805,155.00		
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	694,010,200.00	694,010,200.00	-	100
131001	Улсын төсвөөс санхүүжих	694,010,200.00	694,010,200.00	-	100
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	93,780,100.00	1,794,955.00		
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,759,955.00	-1,759,955.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	35,000.00		100
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	93,745,100.00	-	93,745,100.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	95,576,563.86		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	173,785,991.59		-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан: Орон нутаг

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	48,152,500.00	33,796,760.50	14,355,739.50	-
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	48,152,500.00	33,796,760.50	14,355,739.50	-
210	Бараа, үйлчилгээний зардал	48,152,500.00	33,796,760.50	14,355,739.50	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,152,500.00	24,796,760.50	14,355,739.50	63.33
210301	Гэрэл цахилгаан	7,000,000.00	1,960,201.78	5,039,798.22	28.00
210302	Түлш, халаалт	29,152,500.00	22,836,558.72	6,315,941.28	78.33
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	-	3,000,000.00	-
2106	Эд хогшил худалдан авах	9,000,000.00	9,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	9,000,000.00	9,000,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	48,152,500.00	48,152,500.00	-	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	48,152,500.00	33,796,760.50	14,355,739.50	70.19
132001	Орон нутгийн төсвөөс	48,152,500.00	33,796,760.50	14,355,739.50	70.19
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

3. Аудитын тайлан

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Засгийн газрын 2024 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал”-д сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрт технологийн дэвшил, хүний хөгжлийн онцлог, хэрэгцээтэй уялдуулан хүн болохуй, суралцахуйн олон янзын олон талт арга замыг тусгасан хөтөлбөрийг хөгжүүлж, хэрэгжүүлэх шаардлага нэгэнт бий болсныг онцолсон байна.

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Хүүхдийн цэцэрлэг нь бага насны хүүхдийн насан туршийн боловсрол олгох үндэс суурийг тавих, зөв дадал хэвшилтэй зөв монгол иргэнийг бий болгох, хүүхдийн эрхийг дээдлэн хамгаалж, баяр баясгалантай, эрүүл аюулгүй орчинд ээлтэй хамт олныг бүрдүүлэх, тус цэцэрлэг нь “2-5 хүртэлх насны хүүхдийн танин мэдэхүй, эрүүл мэнд, нийгэмшихүй, сэтгэл

хөдлөлийг хөгжүүлэхэд гүйцэтгэл төвтэй төлөвлөлтөд суурилан бүх талын оролцоо, хамтын ажиллагааг хангаж, сургалт, хөгжүүлэх үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулах” гэсэн зорилгыг тавьж ажилласан байна.

Зорилгоо биелүүлэхийн тулд дараах зорилтыг тавьж ажилласан байна. Үүнд:

- Хүний нөөцийн чадамжийг сайжруулж, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах боломжоор ханган багш, ажилчдын мэргэжлийн онол, цахим, арга зүйн мэдлэг, чадамжийг сайжруулахад чиглүүлж, ахиц үр дүнг тооцох;
- Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт нийцүүлэн зураг, дүрс, тэмдэгт мэдээллийн утга санааг ойлгох, бичвэр эхийг уншиж ойлгох, илэрхийлэх, тайлбарлах чадварыг өдөр тутам сургалт хөгжүүлэх үйл ажиллагаанд үр дүнтэй бүтээлчээр хэрэгжүүлэх;
- Багшийн ажлын байран дахь мэргэжлийн хамтын ажиллагааны үр дүнг сайжруулж, хичээл сургалтын үйл ажиллагааг мэргэжлийн багш нарын бүлэг багаар хамтран хүүхдийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн чанартай бэлтгэн Хүүхдийн төв болгож үр дүнтэй хэрэгжүүлэх;
- Багш ажилтны бүтээлч үйл ажиллагаа, мэргэжлийн бие даасан байдлыг хүндэтгэсэн харилцаа, хамтран ажиллах болон сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлж байгууллагын эерэг уур амьсгал, соёл төлөвшүүлэх;
- Бие даан суралцаж цахим, мэдээлэл технологийн мэдлэгээ сайжруулах;
- Цахим технологид суурилсан сургалтын болон суралцахуйг дэмжсэн платформын ашиглалтыг нэмэгдүүлэх;
- Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг тэгш хамруулж тэдний онцлог, хэрэгцээнд суурилан хөгжлийн дэмжлэгийг чанар, үр дүнтэй үзүүлэхэд талуудын оролцоо, хамтын ажиллагааг идэвхижүүлэх

Тус цэцэрлэгийн эрхлэгч нь Боловсрол шинжлэх ухааны газрын даргатай 7 чиглэлээр 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө баталж, үр дүнгийг гэрээ байгуулсан байна. 2024.12.27 ны өдөр Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн ажил үнэлж, дүгнэх ажлын хэсэгт ажлаа дүгнүүлэн 2025 оны 01 дүгээр сарын 15-ний өдрийн 1/20 тоот тушаалаар үнэлгээг баталгаажуулсан байна. Төмөрбулаг сум Хүүхдийн цэцэрлэг нь 2024 онд ажлын үр дүнгийн үнэлгээгээр 91%-иар үнэлэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Тус байгууллагын үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой дараах хууль эрх зүйн актад өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /2024.01.01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн/
- Нийгмийн даатгалын багц хууль /2024.01.01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн/
- Засгийн газрын 2024 оны 237 дугаар тогтоол “Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай “
- Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоол “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”
- Засгийн газрын 2024 оны 53 дугаар тогтоол “Тогтоолын хавсралт шинэчлэн батлах тухай /Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээ, түүний бүрэлдэхүүн/”
- Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоол “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу эрхлэгчийн 2024 оны 11 сарын 07 өдрийн А/30 тоот тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын багийг шинэчлэн байгуулсан байна. 2024 онд нийт 4 чиглэлээр 18 ажил төлөвлөн хяналт үнэлгээ хийж зөвлөн тусалж хамтран ажиллаж илэрсэн зөрчилийг арилгах арга хэмжээ авч ажилласан байна.

Аудитаар дотоод хяналтыг хангалттай хэрэгжүүлсэн гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа бодлогын баримт бичгийг аймгийн Засаг даргын 2019 оны А/375 тушаалаар баталж мөрдсөн байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, боловсролын салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Боловсролын яам, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төмөрбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны А/388 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар хүчингүй болгосон бөгөөд 2024 оны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг шинэчилсэн журмаар бүртгэхээр өөрчлөлт оруулан баталсан байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 86,642.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	95,576.6	173,786.0	78,209.4
Бараа материал	55,148.8	54,751.2	-397.7
Үндсэн хөрөнгө	162,180.5	171,421.7	9,241.2
Нийт хөрөнгө	320,627.9	407,269.9	86,642.0
Өр төлбөр	452.0		-452.0
Засгийн газрын хувь оролцоо	320,175.9	407,269.9	87,094.0
Хуримтлагдсан үр дүн	100,282.4	187,629.9	87,347.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	67,131.6	66,878.0	-253.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	320,627.9	407,269.8	86,641.9

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, авлага, өр төлбөрийг данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна. Тайланд онд дээрх данстуудад орсон өөрчлөлтийг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нэмэгдсэн нь 2024 оны төсөвт баталж өгсөн өмнөх оны үлдэгдэл хөрөнгийг бүрэн зарцуулаагүйтэй холбоотой байна.
1. Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь хангамжийн материал, бусад хангамжийн материал өмнөх оноос 397.7 мянган төгрөгөөр буурсан байна.
2. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 9,241.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар БЕгазар Хөвсгөл аймгийн Боловсролын газраас ирсэн техник тоног төхөөрөмж, ЕГ-н хөрөнгө оруулалтаар тавилга эд хогшил хүлээн авсантай холбоотой байна.

БШУС-ын 2024.05.27-ын өдрийн А/259 дугаар тушаалаар сургалтын тоног төхөөрөмж хэрэглэгдэхүүний нөхөн хангалтын санхүүжилтэд 2,811,20 мянган төгрөгийн санхүүжилт авч сургалтын орчин нөхцөлийг сайжруулсан байна.

Аудитаар дараах зөрчил илэрсэн. Үүнд:

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн шинжтэй нийт 5,486.2 мянган төгрөгийн өртөгтэй 11 нэр төрлийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн зөрчил илэрсэн. Энэ нь УСНББОУС-17, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан журмын холбогдох заалтыг зөрчсөн ба ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материал дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг тус дансанд зөв ангилан залруулж, цаашид холбогдох стандарт, журмыг баримтлан ажиллах

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсөв 83060,0 мянган төгрөгөөр Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ИТХ-д, Боловсрол шинжлэх ухааны яаманд улсын төсвөөс 699270,9 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төсвийн санал хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны 01-р сарын 15-ний өдрийн А/07 тоот тушаалаар 695,805.2 мянган төгрөг Төмөрбулаг сумын ИТХ-ын 2023 оны 12-р сарын 19-ны өдрийн хуралдааны 07 тоот тогтоолоор манай байгууллагын төсвийн зарлагыг 48,152.5 мянган төгрөгөөр баталсан

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Хөтөлбөр арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Улсын төсөв				
81,605	Эрүүл мэндийг дэмжих	1,527.60	1,235.30	292.3
81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	50,475.40	28,544.80	21,930.6
80,233	Хүүхэд хамгааллын зардал	930.60	930.6	0.0
81,816	Нөхөн хангалтын зардал	2,836.20	2,811.20	25.0
81,823	Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1,443.10	1369.2	73.9
81,834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	680,550.00	547837.9	132,712.1

81,835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	5,709.60	4,845.10	864.5
	Нүүдлийн бүлэг	31,808.70	22,194.20	9,614.5
	Явуулын бүлэг	12,474.10	7,827.40	4,646.7
	Дүн	787,790.30	651,392.50	136,397.80
	Орон нутаг			
	Байр ашиглалттай холбоотой зардал	48,152.50	33,796.80	-14,355.70
	НИЙТ	835,942.80	685,189.30	

Төсвийн гүйцэтгэл болон зарцуулалттай холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

1. Тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2024 оны 08 сарын 19-ны өдрийн Б/04 тушаалаар байгууллагын нягтлан бодогчид 2 сарын, няравт 1 сарын үндсэн цалингаар тус тус балансын урамшуулал олгохдоо ажлын үр дүнг үнэлээгүй, ямар шалтгаанаар 1-2 сарын үндсэн цалин 3,984.0 мянган төгрөгийг олгож байгаа нь тодорхойгүй зөрчил илэрч байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасныг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгссөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудыг урамшуулахдаа ажлын үр дүнг бодитой тооцож, улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулахгүй байхад анхаарч ажиллах

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь нэмэлт санхүүжилтийн дансгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Гадаад дотоодын төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төмөрбулаг сумын хүүхдийн цэцэрлэг нь төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг болох Худалдан авсан бараа ажил үйлчилгээний гүйцэтгэлийг Төсвийн тухай хуулийн 54.5.3-д заасны дагуу гаргаж тайлагнасан байна. Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг татан хянахад хүнсний материалыг 4 багц болгон тендер зарлаж, шалгарсан бэлтгэн нийлүүлэгчтэй 164,055.4 мянган төгрөгийн гэрээ байгуулж ажилласан байна. Түлш халаалт, цэвэр бохир ус, гэрэл цахилгаан гэсэн нэг бэлтгэн нийлүүлэгчтэй бараа ажил үйлчилгээг шууд гэрээ байгуулах аргаар худалдан авалтыг хийж бусад бараа ажил үйлчилгээг шууд худалдан авах аргаар, худалдан авах ажиллагааны тайланг шилэн дансанд байршуулсан, батлагдсан төсөвт туссан арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай байдлаар төлөвлөж, үр дүнг тайлагнаж ил тод мэдээлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1¹, 46 дугаар зүйлийн 46.1² -т заасныг зөрчөөгүй ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангасан байна.

3.6 Ерөнхий чиглэлийн хүрээнд авч хэрэгжүүлсэн судалгааны үр дүн: Төмөрбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 5 чиглэлээр судалгаа авч, үр дүнг тайланд тусгалаа.

3.6.1 Ахмадын сан

Тус байгууллага нь ахмадын сан байгуулж, жилийн төсөвтөө төлөвлөж батлуулаагүй байна. Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "Энэ хуулийн 14.6-д заасан арга

¹ 44.1.Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.

² 46.1.Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана.

хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална", Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-тай нийцэхгүй байна.

Аудитын шийдвэрлэлт: Зөвлөмж өгөх

3.6.2 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төмөр булаг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны худалдан авах ажиллагаа

№	Тендер шалгаруулалтын код	Худалдан авах бараа, ажил үйлчилгээний санхүүжилтын эх үүсвэр, нэр, төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Төсөвт өртөг/мян. Төг/	Худалдан авах ажиллагаанд мөрдөсн журам, арга	Гэрээ байгуулсан дүн /мян.төг/	Гэрээ байгуудсан этгээдийн нэр
1	ХӨАЧХЦ/20240202004	БҮТЭЗүйл	6,000.00	ШХА	6,000.00	Тарважтээл хоршоо
2	ХӨАЧХЦ/20240202002	Тээвэр шатахуун	6,000.00	ШХА	6,000.00	Баян-Энх Айраг
3	ХӨАЧХЦ/20240202001	Бичиг хэрэг	1,000.00	ШХА	883.35	Икосаэдр ХХК
4	ХӨАЧХЦ/20240202006	Нормын хувцас	1,000.00	ШХА	1,000.00	Дөлгөөн цэнгэг нуур ХХК
5	ХӨАЧХЦ/20240202007	Урсгал засвар	9,000.00	ШХА	9,000.00	Хур бороо хоршоо
6	ХӨАЧХЦ/20240202003	Хичээл үйлдвэрлэл	6,451.00	ШХА	6,451.00	Икосаэдр ХХК
7	ХӨАЧХЦ/20240202008	Түлш халаалт	26,152.50	НТШ	26,152.5	Мөнх хүсэл од ХХК
8	ХӨАЧХЦ/20240202005	Хоол, хүнс	55,474.50	НТШ	55,474.5	Энх-Алтан-Од
9	ХӨАЧХЦ/20240202009	Түлээ	3,000.00	ШХА	3,000.0	Эх тавилгант хайрхан
10	ХӨАЧХЦ/20240202010	Тоглоом, зөөлөн эдлэл	2,811.20	ШХА	2,811.2	Энх-Алтан-Од
		ДҮН	116,889.2		116,772.6	

Тайлант онд 12 нэр төрөл дээр 116,772,6 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж, худалдан авах ажиллагааны аргыг журам зааварт заасны дагуу сонгож ажилласан байна.

3.6.3 Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд гүйлгээ гараагүй.

3.6.4 Бараа үйлчилгээний бусад зардал

Бараа үйлчилгээний бусад зардлын дансанд 5 арга хэмжээний хүрээнд 45 ажил гүйлгээгээр нийт 19,597.80 мянган төгрөгийг зарцуулсан ба анхан шатны баримтаар нотлогдож байна.

3.6.5 Байгууллагын бүтэц орон тоо

Төмөрбулаг сумын хүүхдийн цэцэрлэг нь 2024 онд удирдах 1, гүйцэтгэх 9, үйлчилгээний 13, нийт 23 орон тоогоор ажиллахаар батлагдсан ба гүйцэтгэл 100 хувь байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Галт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан соёмбо аудит ХХК-ийн аудитор Н.Ган-Эрдэнэ гүйцэтгэж, анхан шатанд захирал Х.Диймаа хянаж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын хяналтыг аудитор Л.Мөнх-Оргил, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Төмөрбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хаан соёмбо аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 15-ны 02 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 481,194.28 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 9,623.88 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 7,699.10 мянган төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн шатанд тус байгууллагын 2024 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлтэд харгалзан дараах байдлаар материаллаг түвшинг шинэчлэн тогтоов. 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн болох 701,550.05 мянган төгрөгийг суурь үзүүлэлтээр сонгож, хувь хэмжээг 2 хувиар тооцож, 14,031.00 мянган төгрөгөөр материаллаг түвшинг тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг сорилыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд дараах хяналт хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Цалингийн зардлаас бусад 5 саяас дээш зардал, орлогын гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн эсэх
2. Таван сая төгрөгөөс дээших худалдан авах ажиллагааны мэдээлэл болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөө тайланг хугацаанд нь үнэн зөв мэдээлсэн эсэхэд хяналт хэрэгжүүлсэн

Аудитаар зөрчил илэрээгүй болно.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлсэн горим сорилоор зөрчилтэй зүйл илрээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны III улирлын санхүүгийн тайланд завсрын аудитыг хийж, 3 зөвлөмж хүргүүлсэн ба биелэлтийг тооцоход хангалттай байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар илэрсэн зөрчилд өгсөн зөвлөмжийг тайлант онд хэрэгжүүлж ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Аймгийн боловсролын газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн "Урамшуулал олгох тухай" А/85 дугаар тушаалаар эрхлэгчид 1 сарын цалинтай тэнцэх хэмжээгээр урамшуулал олгосон ба ажлын үр дүнг үнэлсэн баримтыг аймгийн Боловсролын газрын санхүүгийн тайланг хянахдаа анхаарч шийдэх нь зүйтэй байна.

2. Боловсролын ерөнхий газраас СӨБ-ын байгууллагуудад "Эй плас интернэйшнл" ХХК -тай гэрээ байгуулж ажиллах, батлагдсан сургалтын зардлын 60 хувийг уг сургалтад зарцуулж байхаар чиглэл өгч, багш нарын сургалтын ирцийг тэдний гүйцэтгэлийн үр дүнтэй шууд холбожээ. Иймд "Эй плас интернэйшнл" ХХК -тай "Багшийн хөгжлийг дэмжих модуль сургалтыг цахим платформоор зохион байгуулах сургалтын үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г 2022 оноос 3 жил дараалан байгуулж, 2024 онд 650.0 мянган төгрөг шилжүүлсэн байна. Компаниас сургалтын төлбөрийг урьдчилан 100 хувь авдаг, байгуулсан гэрээ дүгнэгддэггүй зэргээс харахад тодорхой нэг сургалтын компанийн үйл ажиллагааг бодлогоор зориуд дэмжсэн, үр дүн, ач холбогдол багатай сургалт байгаа тул энэ асуудлыг дараагийн аудитаар анхаарах шаардлагатай байна.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар үндсэн хөрөнгө, бараа материал, төсвийн зарцуулалттай холбоотой 6 зөрчил илрүүлж 4 зөвлөмж хүргүүлсэн.

5.1 Аудитын залруулга

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой залруулга хийгээгүй болно.

5.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.3 Албан шаардлага

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн шинжтэй нийт 5,486.2 мянган төгрөгийн өртөгтэй 11 нэр төрлийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн зөрчил илэрсэн. Энэ нь УСНББОУС-17, Сангийн сайдын 2016 оны 388 дугаар тушаалаар баталсан журмын холбогдох заалтыг зөрчсөн ба ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материал дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг тус дансанд зөв ангилан залруулж, цаашид холбогдох стандарт, журмыг баримтлан ажиллах

2. Зардлын данстай холбоотой

Илрүүлэлт:

Тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2024 оны 08 сарын 19-ны өдрийн Б/04 тушаалаар байгууллагын нягтлан бодогч, нярав нарт 1-2 сарын үндсэн цалингаар урамшуулал олгохдоо ажлын үр дүнг үнэлээгүй, ямар шалтгаанаар 1-2 сарын үндсэн цалин 3984.0 мянган төгрөгөөр олгож байгаа тодорхойгүй зөрчил илэрч байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасныг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудыг урамшуулахдаа ажлын үр дүнг бодитой тооцож, улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулахгүй байхад анхаарч ажиллах

3. Ахмадын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт:

Тус байгууллага нь Ахмадын тухай хуулийн холбогдох заалтын дагуу ахмадын сан байгуулж, жилийн төсөвтөө төлөвлөж батлуулаагүй байна. Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална", Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ахмадын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хууль журмын дагуу байгууллагын төсвийн төсөлдөө ахмадын санг төлөвлөн батлуулж ажиллах

4. Бараа, материалын орлоготой холбоотой

Илрүүлэлт:

2024 оны хичээлийн шинэ жилд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа хүүхдийн хичээлийн хэрэгслэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслэлийн хандивт эцэг эх, асран хамгаалагч нараас өгсөн 6,457.8 зүйлсийг орлогод бүртгэж, санхүүгийн тайланд тусгаагүй байгаа нь Боловсролын ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 24-ны өдрийн а/243 дугаар тушаал, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.5.бүх орлого гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орлогыг бүртгэж тайланд тусгах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргаж, fas.audit.mn системд оруулж, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийн бараа материал дансанд бүртгэсэн	1	5,486.2					1	5,486.2
Урамшуулал олгох шийдвэр гаргахдаа ажлын үр дүнг бодит байдал нийцүүлэн үнэлээгүй зөрчил илэрсэн.	1	3,984.0					1	3,984.0
Эцэг, эхээс авсан ариун цэврийн хэрэгслэл, хичээлийн хэрэглэгдэхүүнийг орлогод авч тайланд тусгаагүй	1	6,457.8					1	6,457.8
Дүн	3	15,928.0					3	15,928.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ахмадын тухай хуулийн дагуу ахмадын сан байгуулж ажиллаагүй.	1	0					1	0
Дүн	1	0					1	0